## НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО

/(2022 оны жилийн эцсийн байдлаар)

2022.12.15 Багахангай дүүрэг

| № | Агуулга | Нийт заалтын тоо | Биелсэн | Хэрэгжих шатандаа | Тасарсан | Хугацаа болоогүй | 90 | 70 | 50 | 30 | 0 | Үнэлэх боломжгүй | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | "Ковид-19" цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого | 8 | 4 | 4 | - | - | 8 | - | - | - | - | - | 90 |
| 2 | Хүний хөгжлийн бодлого | 34 | 27 | 7 | - | - | 34 | - | - | - | - | - | 90 |
| 3 | Эдийн засгийн бодлого | 21 | 11 | 10 | - | - | 17 | 1 | 2 | 1 | - | - | 82 |
| 4 | Засаглалын бодлого | 30 | 15 | 15 | - | - | 28 | - | 2 | - | - | - | 87.3 |
| 5 | Ногоон хөгжлийн бодлого | 13 | 7 | 6 | - | - | 12 | - | - | - | - | 1 | 90 |
| 6 | Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого | 15 | 7 | 8 | - | - | 10 | 3 | 2 | - | - | - | 80.6 |
| 7 | Дүрмээр хүлээсэн чиг үүрэг | 22 | 3 | 18 | - | - | 19 | 2 | - | - | - | - | 88.1 |
| | **НИЙТ** | **142** | **74** | **68** | | | **128** | **6** | **6** | **1** | **-** | **1** | **86.9** |

ХЯНАСАН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Л.САНЖИЙЖАМЦ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.ЭРДЭНЭТУЯА

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Ж.НАРАНЦЭЦЭГ

НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/2022 оны жилийн эцсийн байдлаар/

2022 оны 12 дугаар сарын 15 — Багахангай дүүрэг

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж /ДЗДҮАХ/ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| НЭГ. ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ТУСГАГДСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА | | | | | | | | |
| 1. "КОВИД-19" ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО | | | | | | | | |
| **Зорилт 1.1**. Цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна. | | | | | | | | |
| 1. | Цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор дархлаажуулалтын ажлыг эрчимжүүлж, дүүргийн Эрүүл мэндийн төвийн бэлэн байдлыг хангах, шаардлагатай эм эмнэлгийн хэрэгслээр хангана. | Дүүргийн төсөв 3.0 | Дархлаажуу-лалтад хамрагдсан иргэдийн тоо<br>Хамрагдал-тын хувь<br>Зарцуулсан мөнгөн дүн | 2021 онд коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангах чиглэлээр 197.5 сая төгрөг зарцуулав. | Дархлаажуулалтын бүрэн тунд хамрагдал-тыг 40%-д хүргэсэн байна<br><br>Тухайн жилд зарцуулсан хөрөнгийн хэмжээ | 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар коронавирусын халдварын эсрэг дархлаажуулалтын нэгдүгээр тунд 3134 хүн 95,6%, 2 тунд 2842 хүн 86,7%, 3 тунд 1402 хүн 48,4%, 4 тунд 277 хүн 9,6% тай хамрагдсан байна. Дархлаажуулалтын цэг Эрүүл мэндийн төв дээр өдөр бүр ажиллаж байгаа бөгөөд дархлаажуулалтад хамрагдах мэдээллийг тухай бүр цахимаар иргэдэд хүргэн ажиллаж байна.<br>Дүүргийн Эрүүл мэндийн төв нь халдварт өвчний үед бэлэн байдлыг хангахад 28,5 сая төгрөгний эм, тариа, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж, оношлуурын таталтыг хийсэн байна.<br>Эм, тарианы нөөц 1 сар, халдвар хамгааллын хувцас, хэрэгсэл 3 сарын нөөцтэй байна.<br>Халдвартын 6 орны бэлэн байдлыг хангаж ажиллаж байна. | 100 | 90% |
| 2. | Нөхцөл байдлын мэдээллийг дүүргийн иргэдэд үнэн зөв, бодитой, нэг эх сурвалжаас хүргэх, коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол хүргэнэ. | - | Мэдээллийн тоо<br>Хандалтын тоо | Багахангай хэвлэл мэдээлэл болон холбогдох ААНБ-ын facebook хуудсаар 130 мэдээллийг хүргэж ажилласан. | Иргэд, олон нийт мэдлэгтэй болж, дэглэмийг мөрддөг болсон байна. | Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх хүрээнд дүүргийн www.bagakhangai.ub.gov.mn сайтад КОВИД-19 цар тахлын 68 сэрэмжлүүлэг мэдээ мэдээллийг 320 удаагийн давтамжтайгаар оруулж их хандалттай цахим сайт, байгууллага аж ахуйн нэгжийн фейсбүүк групп, пейж хуудсанд шейрлэж цахим сүлжээгээр дамжуулан олон нийтэд хүргэж ажилласнаар цар тахлын өвчлөл буурсан | 100 | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байна. | | |
| 3. | Коронавирус буюу Ковид-19 цар тахал өвчний улмаас өрхийн орлого буурсан иргэдэд тусламж дэмжлэг олгох ажлыг зохион байгуулна. | - | Тусламж, дэмжлэгт хамрагдсан иргэдийн тоо | Давхардсан тоогоор дүүргийн 1678 өрх 187.3 сая төгрөгийн тусламж дэмжлэгт хамрагдав. | Дүүргийн 350-аас доошгүй өрх, иргэн тусламж дэмжлэгт хамрагдсан байна. | Дүүргийн ХХҮХ нь гэнэтийн аюул ослын улмаас гэр оронгүй болсон 1 өрхийг онцгой тохиолдын амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид хамруулав. Мөн 55 өрхийн 312 иргэнд 18,2 сая төгрөгийн хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлээд байна. Дүүргийн Шуурхай штабын нөөцөд байсан 14 хүнсний багцийг тусламж дэмжлэг шаардлагатай өрхүүдэд олгов. Тайваний хүүхэд гэр бүлийг дэмжих сангаас төсөлд хамрагддаг 52 өрхөд хүнс тэжээлийн тусламжид хамруулсан бол УЗХорооноос зорилтот бүлгийн 20 иргэнд хүнсний тусламж үзүүлсэн байна. | 100 | 90% |
| **Зорилт 1.2** Худалдаа үйлчилгээний байгууллагуудын эрүүл ахуй, халдвараас сэргийлэх дэглэмийн мөрдөлт, халдваргүйжүүлэлтэд хяналт тавина. | | | | | | | | |
| 4. | Худалдаа үйлчилгээний байгууллагуудад мэргэжлийн байгууллагууд хамтран хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэх | - | | Худалдаа үйлчилгээ эрхлэгч 23 ААНБ байна. | 30 ААНБ-ыг халдвар гүйжүүлэлтэд хамруулсан байна. | Дүүргийн нутаг дэвсгэр дэх худалдаа, үйлчилгээний байгууллагуудад халдваргүйжүүлэлт хийх үүрэг даалгаврыг ЗДТГ-ын 2022 оны 8/43 дугаар албан бичгээр хүргэв. Дүүргийн хэмжээнд 30 ААНБ-ын 19452 $м^2$ талбайд халдваргүйтгэлийн ажлыг 11 удаа зохион байгуулж 5 удаа ТХҮХ, МХТасгаас хяналт тавьж ажиллав. | 100 | 90% |
| **Зорилт 1.3** Ариутгал халдваргүйтгэл хийх бодисын нөөц бүрдүүлэх, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, нийтийн тээврийн хэрэгсэлд цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн ажлыг тогтмол зохион байгуулна. | | | | | | | | |
| 5. | Айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагууд, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд халдваргүйтэл хийлгэх арга хэмжээг зохион байгуулах | 1.8 сая төгрөг | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 4 удаа халдваргүйжүүлэлт хийсэн байна. | Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд сар бүр халдваргүйжүүлэлт хийсэн байна. | Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд байрлах автобусны 2 зогсоол, 87ш сандал, 21ш цинк, 70 ширхэг жижиг хогийн савыг тогтмол суллаж, 17 удаа халдваргүйтгэлийг хийж 0.9 сая төгрөг зарцуулав. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлдэг Хийморийн зам ХХК-ны 3 автомашинд 4 удаа халдваргүйжүүлэлт хийв. Хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан ЕБС, СӨБайгууллагуудын орчин, хүүхдийн тоглоомын талбай, дүүргийн төв талбайд 2 удаа зориулалтын автомашинаар мананцар үүсгэн халдваргүйжүүлэлтийг зохион байгуулав. 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 2 удаагийн халдваргүйжүүлэлт хийх бодисын нөөцтэй байна. | 90 | 90% |
| 6. | Халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг тусгай | 1.4 сая төгрөг | Үйл ажиллагаа-ны хэрэгжилт, | - | | Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх, | 90 | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар орц болон зоорийн давхарт 14 хоногт 1 удаагийн халдваргүйжүүлэлтийг хуваарийн дагуу хийлгэх, халдваргүйжүүлэлтийн бодис авч нөөц бүрдүүлэх | | хувь | | | дүүргийн нийтийн эзэмшлийн хүүхдийн тоглоом, спортын талбай болон гэр хорооллын айл өрхийн, нүхэн жорлон, бохирын цооногийг халдваргүйжүүлэх ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 14,15-ны өдрүүдэд зохион байгуулав. 1, 2 дугаар хорооны нийт 228 өрх хамрагдаж, 1,2 дугаар хорооны хэсгийн ахлагч нар хяналт тавьж ажиллав. Тус ажлыг дүүргийн Багахангай тохижилт ОНӨААТҮГ, Цэф трейд ХХК гүйцэтгэхэд Засаг даргын нөөц хөрөнгөөс 1810000 төгрөг зарцуулсан байна. Дүүргийн 1, 2 дугаар хорооны нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд байрлах автобусны зогсоол 2, сандал 87ш, цинкен хогийн сав 21ш, жижиг хогийн сав 70 ширхэгийг тогтмол суллаж, хуваарийн дагуу чийгтэй цэвэрлэгээг 11 удаа хийн, ариутгал халдваргүйтгэлийн ажлыг тухай бүр зохион байгуулан ажиллахад 652 000 төгрөг зарцуулав. Дүүргийн 1, 2-р хорооны 17 байрны 57 орцыг халдваргүйжүүлэх ажлыг 1 удаа зохион байгуулав. Засаг даргын нөөц хөрөнгөөс 804 000 төгрөг зарцуулав. Хангайн өргөө СӨХ 5 байрны 25 орцод 2135м2, Их хангай СӨХ 8 байрны 16 орцод 1800м2 талбайд хардваргүйтгэлийн ажлыг 14 хоногт 1 удаа, Баян хангай СӨХ 1 байр 8 орцод 683,2 талбайд 7 хоногт 2 удаа ариутгалын бодистой чийгтэй цэвэрлэгээг тухай бүр хийж ажиллаж байна. | | |
| 7. | Ариутгал халдваргүйтгэл, хийх бодисын нөөц бүрдүүлэх, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, нийтийн тээврийн хэрэгсэлд цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн ажлыг тогтмол зохион байгуулна. | Дүүргийн Засаг даргын нөөцөөс 5.7 сая | . | 4 удаа халдваргүйжүүлэлт хийсэн байна | Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд сар бүр халдваргүйжүүлэлт хийсэн байна. | Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд байрлах автобусны 2 зогсоол, 87ш сандал, 21ш цинк, 70 ширхэг жижиг хогийн савыг тогтмол суллаж, 17 удаа халдваргүйтгэлийг хийж 0.9 сая төгрөг зарцуулав. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлдэг Хийморийн зам ХХК-ны 3 автомашинд 4 удаа халдваргүйжүүлэлт хийв. Хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан ЕБС, СӨБайгууллагуудын орчин, хүүхдийн тоглоомын талбай, дүүргийн төв талбайд 2 удаа зориулалтын автомашинаар мананцар үүсгэн халдваргүйжүүлэлтийг зохион байгуулав. 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 2 удаагийн | 90 | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | халдваргүйжүүлэт хийх бодисын нөөцтэй байна. | | |
| **Зорилт 1.4** Хүнсээр хангах мэргэжлийн ангиудтай хамтран ажиллаж, хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлнэ. | | | | | | | | |
| 8. | Хүнсээр хангах мэргэжлийн ангиудтай хамтран ажиллах гэрээ байгуулж хэрэгжилтийг хангуулан ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 12 дэлгүүртэй гэрээ байгуулан ажиллаж байна. | Хүнсний нөөцийг бүрдүүлэх гэрээг шинэчилсэн байна. | Нийслэлийн хүнсээр хангах албаны төлөвлөгөө шинэчлэгдсэнтэй холбогдуулан дүүргийн хүнсээр хангах албаны төлөвлөгөөг шинэчлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нөөц бүрдүүлэх гэрээг 12 хүнсний дэлгүүртэй байгуулж 7 хоног бүрийн Баасан гарагт хүнсний гол нэрийн 13 бүтээгдэхүүний нөөцийн мэдээг ЗАА-нд хүргүүлж байна. Онцгой байдлын хэлтэс нь дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд 1 удаа тодотгол хийж хүнсээр хангах албатай хамтран дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй 4 худалдаа үйлчилгээ байгууллагатай хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулав. Хүн амын хүнсний хэрэгцээнд махны хангамжийг нийлүүлэх зорилгоор нөөцийн махны жижиглэн худалдааг Сэтгэлийн гэгээ ХХК, Хангай булаг ХХК–ны хүнсний дэлгүүрээр дамжуулан үхрийн мах 2540 кг, хонины мах 2640 кг, борлуулалт хийсэн байна. Дүүрэгт нөөцийн махны өргөтгөсөн худалдааг 4 удаа зохион байгуулж 4.93 тн мах худалдаалав. | 90 | 90% |
| Дундаж хувь | | | | | | | 95 | |
| Үнэлгээ | | | | | | | | 90 |
| 2. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | | |
| **Зорилт 2.1. Эрүүл мэнд:** Нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэдэд эрүүл зөв амьдралын дадлыг хэвшүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ. | | | | | | | | |
| 9. | Дүүргийн Эрүүл мэндийн төвийн эмч, ажилчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж, дутагдалтай байгаа мэргэшсэн боловсон хүчнээр хангана. | - | Сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн ажилчдын тоо<br>Шинээр ажилд орсон эмч, ажилтны тоо | 17 удаагийн сургалтад давхардсан тоогоор 34 эмч, | 80-аас доошгүй эмч, эмнэлгийн ажилтныг сургалтад | Дүүргийн Эрүүл мэндийн төвийн бүтэц 31 орон тоотой байхаар батлагдсан бөгөөд 29 эмч, эмнэлгийн ажилтан иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлж байна. Эрүүл мэндийн төв сул орон тооны зарыг НЭМГ-т 11, байгууллагын вэб сайт болон цахим хуудаст 31, эрүүл мэндийн салбарын facebook нэгдсэн группэд 12 удаа байршуулан ажлын байрны захиалгыг дүүргийн ХХҮХ-т 4 удаа хүргүүлээд байна.<br>2022 онд дүрс оношилгооны эмч, нийгмийн эрүүл мэндийн сувилагчийг байнгын, | 100 | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | эмнэлгийн ажилтныг хамруулсан. | хамруулж, шаардлагатай боловсон хүчнээр хангасан байна. | дурангийн болон лабораторийн эмчийг гэрээгээр ажиллуулж байна. Эмч, эмнэлгийн ажилтны мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор ЭМЯ, НЭМГ болон бусад байгууллагаас цахимаар зохион байгуулсан 42, танхимаар зохион байгуулсан 39 удаагийн сургалтад давхардсан тоогоор 134 эмч, эмнэлгийн ажилтныг хамруулав. Эрүүл мэндийн төв дотоод сургалтыг цахимаар 19, танхимаар 13 удаа зохион байгуулав. | | |
| 10. | Эрүүл мэндийн төвийг автомашинаар хангах, шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалтыг гарган холбогдох байгууллагуудад уламжлах | Нийслэ-лийн төсөв 100.0 | Нэмэгдсэн, автомашины тоо Шаардлагатай тоног төхөөрөмжийн тоо | 64.5 сая төгрөгийн өртөг бүхий 9 төрлийн тоног төхөөрөмжөөр хангагдсан. | Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. | Дүүргийн Эрүүл мэндийн төв нь ЭМЯ, НЭМГ, “Их өргөө ротари клуб” ТББ-ын санхүүжилтээр 5 нэр төрлийн 277.0 сая төгрөгийн багаж тоног төхөөрөмжөөр хангагдав. Эрүүл мэндийн төв лабораторийн үйл ажиллагааг стандартын дагуу явуулж 12 нэр төрлийн шинжилгээнд давхардсан тоогоор нийт 4491 иргэнийг хамруулав. | 100 | 90% |
| 11. | Орон нутагтаа нарийн мэргэжлийн эмч нартай хамтарч 2 удаа үзлэг оношилгоог зохион байгуулна. | Засаг даргын нөөц | Үзлэгт хамрагдсан иргэдийн тоо | 252 иргэнийг амны хөндийн үзлэгт хамруулав. | 2-оос доошгүй нарийн мэргэжлийн эмчийн үзлэг зохион байгуулсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дүгээр тушаал, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 06 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгийг 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлүүлэн насны ангиллаар иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулж байна.<br>Тус үзлэгт 4453 иргэн хамрагдахаас 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 1182 хүн хамрагдаж, хамрагдалт 26,5%-тай байна. Сүрьеэтэй тэмцэх нийгэмлэгтэй хамтран 06 дугаар сарын 02-06-ны өдрүүдэд “Сүрьеэгийн эрт илрүүлгийн үзлэг”-ийг зохион байгуулж, 452 иргэнийг хамруулан 5 тохиолдол илрүүлж, эмчилгээнд хамруулав. Улсын төв 2 дугаар эмнэлэгтэй хамтран ажиллах “Санамж бичиг”-ийн дагуу 11 дүгээр сарын 30, 12 дугаар сарын 01-ний өдрүүдэд чих хамар хоолой, нүдний нарийн мэргэжлийн 2 эмчийг дүүрэгт ажиллуулж 148 иргэнийг үзлэгт хамруулав. | 100 | 90% |
| 12. | Иргэдийн нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй | Нийслэл, дүүргийн төсөв 1.0 | Зохион байгуулсан сургалт, хамрагдсан | Халдварт бус өвчний | Халдварт бус өвчний урьдчилан сэргийлэх | Эрүүл мэндийн төв 2022 онд иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох 4 бүлэг 26 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100 | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | өвчнөөс урьдчилан сэргийлэх зөв дадал хэвшилд сургах, эрүүл зохистой хооллолтыг дэмжих чиглэлээр 5 сургалт зохион байгуулна | | иргэдийн тоо | урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлж, эрт үед нь эмчилсэн. | сургалт нөлөөллийн арга хэмжээг 5-аас доошгүй удаа зохион байгуулсан байна. . | Сургалт, нөлөөллийн арга хэмжээг 16 удаа зохион байгуулж, 276 иргэнийг хамруулан 23 төрлийн 1831 материалыг тараасан байна. "Багахангай Эрүүл мэндийн төв", "Bagakhangai sport" цахим хуудаст 657 зөвлөгөө, зөвлөмжийг байршуулж, нийт 4135 иргэн хандалт хийсэн байна.<br>"Илүүдэл жингүй эртэч Монгол", "Ажлын байрны дасгал хөдөлгөөн" аяныг өрнүүлэн давхардсан тоогоор 6765 иргэнийг хамруулав.<br>Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор ЭМТ 2022 оны 10 дугаар сараас Нийгмийн эрүүл мэндийн сувилагчийг ажиллуулж эхлээд байна. | | |
| 13. | "Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" хөтөлбөрийг үргэлжлүүлж, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдэлээс бага насанд нь сэргийлэх олон талт арга хэмжээ зохион байгуулах | Дүүргийн төсөв 4.0 | Зохион байгуулсан ажлын тоо хэмжээ Үзлэгт хамрагдсан хүүхдийн тоо | Урьдчилан сэргийлэх үзлэгт 300 хүүхэд хамрагдсан. | Урьдчилан сэргийлэх үзлэгт 500 хүүхэд хамрагдсан байна. | "Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" хөтөлбөрийн хүрээнд Эмальдент хувийн шүдний эмнэлэгтэй гэрээ байгуулан, 14 хоног тутамд үзлэг, оношилгоо хийж, эмчилгээ, үйлчилгээ, заавар, зөвлөгөө өгч ажиллаж байна. Бага насны хүүхдүүдийн шүдний өвчлөлийг эрүүлжүүлэх зорилгоор 5, 10-р саруудад ерөнхий боловсролын Хангай цогцолбор сургуулийн 1-5 дугаар ангийн 172 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт оруулснаас, 73 хүүхдийг эмчилгээнд хамруулсан байна.<br>Эрт илрүүлэг үзлэгт 0-17 насны 370 хүүхдийг хамруулж амны хөндийн эрүүл мэндийн үзлэг хийв. | 90 | 90% |
| 14. | "Эрүүл орчин-Иргэдийн сайн сайхан" III шатны арга хэмжээний төлөвлөгөөгний хэрэгжилтийг хангаж ажиллах | Засаг даргын нөөц | Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, хувь | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж батлуулсан. | Хорт зуршлаас урьдчилан сэргийлэх сургалтууд зохион байгуулсан байна. | "Эрүүл орчин-Иргэдийн сайн сайхан" арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 90%-тай байна. Тайлангийн хугацаанд ИТХ, ГХУСАЗСЗ, ЗДТГ, Багахангай дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс, ГБХЗХХ, ХХҮХ, ХЦС, Хороод, "Хамтарсан баг" хамтран 12 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор 1645 иргэн, хүүхэд залуучуудыг хамруулсан байна.<br>"Зөвийг зөвлөе", "Намайг алгас" аяныг зохион байгуулж байна.<br>Нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлж буй архины хамааралтай иргэдийн зан үйлийг засах "Урам" зорилтот төслийн хүрээнд ГБХЗХХ, Насан туршийн боловсролын | 100 | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | багштай хамтран "Архины хор уршиг", "Боломж таны гарт" сургалт, "Хорт зуршлаас ангид Ирээдүй" хэлэлцүүлэг, "Хорт зуршил хорондоо бус –Хүндээ" зан үйл засах уулзалт, цахим сүлжээгээр сэрэмжлүүлэг, мэдээллийг хүргэн ажиллаж 230 иргэн, хүүхэд залуучуудыг хамруулав.<br>ЗДТГ, Цагдаагийн хэлтэс, Хороод хамтран байнга архи согтууруулах ундаа хэрэглэдэг, архидалт зохион байгуулдаг 16 өрхөөр орж нөхцөл байдалтай танилцан анхааруулга, сэрэмжлүүлэг зөвлөгөө өгч, 11 иргэнийг нийтийг хамарсан ажил, сургалт, нөлөөллийн арга хэмжээнд хамруулснаас гадна гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй иргэдэд хяналтын хувийн хэрэг нээж хяналтад авч ажиллаж байна.<br>Дүүргийн ИТХ, Жендерийн салбар хорооны дэмжлэгээр Эрэгтэйчүүдийн хөгжлийн нийгэмлэгтэй хамтран "Аддиктологийн нийгмийн ажилтан" бэлтгэх сургалтад 5 албан хаагчийг хамруулан 2.0 сая төгрөг зарцуулав. | | |
| 15. | Хотын хөгжлийн индексийн анхан шатны мэдээллийг нэгтгэн Дүүргийн 2021 оны датаг холбогдох байгууллагад хүргүүлэх | - | Дата мэдээллийг нэгтгэсэн байдал | 6 бүлгийн 51 үзүүлэлтийн датаг холбогдох байгууллагад хүргүүлэв. | Дата мэдээллийг холбогдох байгууллa-гад цаг хугацаанд нь хүргэсэн байдлаар тооцно. | 2021 оны индексийг тооцож 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Хороодоос анхан шатны мэдээллийг авч нэгтгэн НЗДТГ-т хүргүүлэн ажилласан. | 100 | 90% |
| **Зорилт 2.2. Биеийн тамир:** Иргэдийг нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх нөхцөл боломжоор хангана. | | | | | | | | |
| 16. | Мэргэжлийн холбоодтой хамтран дүүрэгт улс, бүсийн чанартай тэмцээн уралдаан зохион байгуулах, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн биеийн тамир, спортын арга хэмжээнүүдийг зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. | Засаг даргын нөөц | Зохион байгуулсан ажлын тоо, хэмжээ Тэмцээн уралдаанд | 2021 онд 5 тэмцээн зохион байгуулж 632 иргэнийг хамруулав. | Мэргэжлийн холбоодтой хамтран дүүрэгт улс, бүсийн чанартай 2-оос доошгүй тэмцээн уралдаан | ЗДТГ, Монголын хэт холын марафон гүйлтийн холбоотой хамтран 2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр "Багахангай марафон 2022" улсын аварга шалгаруулах тэмцээнийг 100 км, 50км, буухиа, өсвөрийн аварга, дүүргийн аварга гэсэн 5 төрлөөр зохион байгуулав. Энэхүү тэмцээнд 14 аймаг, 7 дүүрэг, 8 холбоодын 350 гаруй тамирчид, гадаадын 6 тамирчин оролцож 15,0 сая төгрөг зарцуулав. БТСХ нь Монголын Сагсан бөмбөгийн холбоо, Гимнастикийн холбоо, Үндэсний бөхийн холбоо, Чөлөөт бөхийн мастеруудын холбоо, Мөсний сур, Мөсний шагайн холбоо, Хөл | 100 | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | оролцсон иргэдийн тоо | | зохион байгуулсан байна. | бөмбөгийн холбоо, Бөх хурах дэвжээтэй хамтран 10 төрлийн тэмцээн зохион байгуулж 370 тамирчдыг оролцуулсан байна. Нийтийн биеийн тамир, спортын чиглэлээр 2022 онд дүүрэгт 18 тэмцээн, уралдаан зохион байгуулагдаж давхардсан тоогоор 8935 иргэн хамрагдан 8.7 сая төгрөг зарцуулав.<br>Нийслэлийн иргэдийн спортын X наадамд 5 төрөлд 76 тамирчин оролцсоноос ширээний шагайн наадгайн эрэгтэй төрөлд хошой алтан медаль хүртэв. | | |
| 17. | Дүүргийн 2 дугаар хороонд Спорт цогцолборын барилга барих ажлыг эхлүүлнэ. | Улсын төсөв 500.0 | Барилгын ажлын явц, хувь | Зураг төсөв хийгдсэн мөн газрын асуудал шийдэгдсэн. | Спорт цогцолборын барилга бариулах төсвийг улсын төсөвт суулгуулан барилгыг эхлүүлсэн байна. | Дүүргийн 2 дугаар хороонд баригдах Спорт заалны барилга 1,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд үнийн өсөлтөөс шалтгаалан гүйцэтгэгчийн зүгээс барилгын төсөвт магадлал хийлгэж нийт 2,4 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр болоод байна.<br>2022 оны улсын төсөвт 500.0, 2023 онд 815.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэв.<br>Тус барилгын ажлыг Алтай шар говь ХХК 4 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлүүлж 10 дугаар сар хүртэл барилгын 1, 2 дугаар давхрын цутгалтын ажил хийгдээд байна. | 100 | 90% |
| 18. | Дүүрэгт иргэд, олон нийтэд зориулсан . Усан спорт, сургалтын төвийн зураг төсвийг хийлгэх | Улс, Нийслэлийн төсөв 80.0 | Зураг төсвийн ажлын явц, хувь | - | Усан спорт, сургалтын төвийн зураг төсвийг хийлгэсэн байна. | Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/298 дугаар захирамжаар дүүрэгт баригдах "Усан спорт, сургалтын төв"-д 1500м2 газрыг эзэмшүүлэхээр шийдвэрлэв. Зураг төсөв хийлгэх 80.0 сая төгрөгийг Нийслэлийн 2022 оны төсөвт суулгуулсан ба Усан спорт сургалтын төвийн зураг төсвийн ажлыг 79.5 сая төгрөгөөр "Скэч" ХХК гэрээний дагуу гүйцэтгэж байна. | 90 | 90% |
| **Зорилт 2.3 Боловсрол:** Хүн бүрт чанартай боловсролыг тэгш хүртээмжтэй эзэмших нөхцөлийг бүрдүүлж, мэргэжлийн боловсон хүчнээр хангана. | | | | | | | | |
| 19. | Багш нарыг мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх сургалтад үе шаттай хамруулна. | - | Сургалтад хамрагдсан багш нарын тоо, хувь | 12 удаагийн онлайн болон танхимын сургалтад 118 багш хамрагдсан. | Багш нарыг үндсэн болон төрөлжсөн сургалтад бүрэн хамруулсан байна. | СӨБ: 2021-2022 оны хичээлийн жилд 30 удаагийн сургалтад давхардсан тоогоор 60, 2022-2023 оны хичээлийн жилд 5 төрлийн сургалтад 43 багш ажилтан хамрагдав.<br>ЕБС: 2021-2022 оны хичээлийн жилд 10 удаагийн сургалтад 129, 2022-2023 оны хичээлийн жилд 84 багш хамрагдав.<br>"Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ"-ээр Хангай цогцолбор сургууль 4-р түвшинд эрэмбэлэгдэж 19.7, сая СӨБ-ын | 100 | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагын үнэлгээгээр 44 дүгээр цэцэрлэг 2-р түвшинд эрэмбэлэгдэж 18.0 сая төгрөгийн урамшуулал авсан байна. | | |
| 20. | ЕБС, СӨБ-ын сургалтын хэрэглэгдэхүүн, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг сайжруулж, хүүхдэд ээлтэй эрүүл аюулгүй орчинг бүрдүүлнэ. | Нийслэл орон нутгийн төсөв, ОНХС, Гадаадын зээл тусламж | Тоног төхөөрөмжөөр хангагдсан байгууллагын тоо | 73 төрлийн 312 ширхэг сурах бичиг сургалтын хэрэглэгдэхүүнээр хангагдсан. | 2 байгууллагыг сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангасан байна. | Дүүргийн Засаг даргын 2022 оны А/60 дугаар захирамжаар сургууль, цэцэрлэгийн орчны аюулгүй байдалд 2 удаа үзлэг, шалгалт зохион байгуулав. Хүүхдийн сурч хөгжих орчныг сайжруулах зорилгоор ИТХ, ЗДТГ, холбогдох аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран боловсролын салбарт 171.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийв. Үүнд: Сургуулийн хүүхдийн автобус 60.0 сая, ЕБС, СӨБ-д 8.9 сая төгрөгийн 19 ширхэг камер, тоног төхөөрөмжийн шинэчлэлт, 0.5 сая төгрөгийн тоглоом, 17 ширхэг замын тэмдэг тэмдэглэгээг шинэчлэн 2.3 сая, авто машины зогсоол, биеийн тамир, тоглоомын талбай, Алтай бүлгийн их засвар, гадна тохижилтын зураг төсөв хийлгэхэд 46.5, 44-р цэцэрлэгийн барилгын шугам сүлжээ, холболтын зураг төсвийг хийлгэхэд 35.0 сая төгрөг тус тус зарцуулав. БШУЯ, Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй Боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд ЕБС-д А3 өнгөт принтер, Dell маркийн notebook олгоод байна. Жайка ОУБ-тай хамтран хэрэгжүүлж буй "Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах II шатны төсөл"-д Хангай цогцолбор сургууль, 44, 207 дугаар цэцэрлэгийг хамруулж 15.0 сая төгрөгийн тохижилт, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангав. | 100 | 90% |
| 21. | Ээлжийн ажилтай иргэд, алслагдсан өртөө зөрлөг, малчин өрхийн хүүхдүүдийг ая тухтай сурч боловсроход дэмжлэг үзүүлэн хүүхэд харах үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, 100 хүүхдийн ортой сургуулийн дотуур байр барих ажлыг эхлүүлнэ. | Орон нутгийн төсөв | Барилгын ажлын явц, хувь | 70 хүүхдийн ортой сургуулийн дотуур байрны зураг төсвийг хийлгэсэн байна. | | "Хангай" цогцолбор сургуулийн 70 ортой хүүхдийн дотуур байр барих ажлын зураг төсвийг "Шувууны хайрга" ХХК гүйцэтгэсэн бөгөөд 23.8 сая төгрөг зарцуулав. 2022 онд нийслэлийн төсөвт тус барилгын ажилд зарцуулагдах 500.0 сая төгрөгийг суулгуулсан боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хасагдаад байна. | 100 | 90% |
| 22. | Тусгай хэрэгцээт /хөгжлийн бэрхшээлтэй/ хүүхдийг үе | Нийслэл, Орон | Нийт суралцагчдад | Тусгай хэрэгцээт /хөгжлийн | | Дүүргийн Засаг даргын 2022 оны А/37 дугаар захирамжаар "Боловсролд хамрагдалтыг | 100 | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тэнгийнхэнтэйгээ хамт суралцах боломжийг бүрдүүлнэ. | нутгийн төсөв | ХБХүүхдийн эзлэх хувь | бэрхшээлтэй/ хүүхдийг үе тэнгийнхэнтэйгээ хамт суралцах нөхцөл боломжийг бүрдүүлсэн байна. | ХБХүүхдийн эзлэх хувийг нэмэгдүүлсэн байдлаар тооцно | дэмжих зөвлөл"-ийг 10 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан хурлыг 2022 оны 04 дүгээр сард зохион байгуулав. Боловсролын үйлчилгээнд хамрагдаагүй 6 хүүхэд, тэдний асран хамгаалагч, эцэг эхтэй уулзалт зохион байгуулж 2 хүүхдийг насан туршийн боловсролд, 3 хүүхдэд ганцаарчилсан тусгай хөтөлбөрөөр боловсролын үйлчилгээ үзүүлэх, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 1 хүүхдэд сэргээн засах үйлчилгээ үзүүлэхээр шийдвэрлэв. Дүүргийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 24 хүүхэд бүртгэлтэй байгаа ба ерөнхий боловсролын сургуульд 9, МСҮТ-д 1, СӨБ-д 2, Насан туршийн боловсролд 2 хүүхдийг хамруулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 58.3 хувийг боловсролын үйлчилгээнд хамруулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хүртээмжтэй орчныг нэмэгдүүлэх "Старт 2" төслийг сургууль цэцэрлэгт хэрэгжүүлэн 15.0 сая төгрөгийн дэмжлэг авч, орчин нөхцөлийг сайжруулав. Тус төслийн хүрээнд 29 багшийг тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах арга зүйд сургах 10 удаагийн сургалтад хамруулав. | | |
| 23. | Сургууль цэцэрлэгийн "Үдийн хоол" хөтөлбөрийг хэрэгжүүлэн хүүхдийг эрүүл, баталгаат хоол хүнсээр хангахад хяналт тавина. | Нийслэлийн төсөв, орон нутгийн төсөв | Үдийн хоол хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн тоо Хяналт шалгалтын тоо | 411 хүүхдийг үдийн цай хөтөлбөрт хамруулав. | Сургууль цэцэрлэгүүдийн цайны газрын тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх талаар дээд шатны байгууллагад уламжилсан байна.. | Үдийн хоол хөтөлбөрт 411 сурагч хамрагдаж байна. Тайлангийн хугацаанд Хангай цогцолбор сургуулийн цайны газрын эрүүл ахуй орчин нөхцөл болон хүүхдэд норм нормативын дагуу хоол хүнс олгогдож байгаа эсэхэд НМХГ-аас 3 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 1, дүүргийн 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 3 удаа зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулж заавар, зөвлөгөө өгч ажиллав.<br>2022-2023 оны хичээлийн жилээс "Хангай" цогцолбор сургууль мэргэжлийн хоол зүйчийг ажиллуулж эхлээд байна.<br>СӨББ-үүд нь хоол хүнсний материалыг "Налайх хангамж" ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан татан авалтыг хийж, эрүүл ахуйн шаардлага хангасан илчлэг тэжээл сайтай хоол хүнсээр хүүхэд багачуудад үйлчилж байна.<br>Хангай цогцолбор сургуулийн үдийн цайны тоног төхөөрөмжийг сайжруулах хүсэлтийг | 100 | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | БШУЯ, Нийслэлийн Засаг дарга, Засаг даргын орлогч, Боловсролын ерөнхий газар, Орика Монголиа ХХК-д тус тус хүргүүлээд байна. | | |
| 24. | Насан туршийн боловсролын төв байгуулах ажлыг холбогдох байгууллагад уламжилж, иргэд, хүүхэд, залуучуудад насан туршийн боловсрол олгох арга хэмжээг зохион байгуулна. | - | Зохион байгуулсан ажлын тоо, хэмжээ | Насан туршийн боловсролын 2 багшийн асуудлыг шийдвэрлүүлсэн. | Насан туршийн боловсролын үйл ажиллагааг эрчимжүүлсэн байна. | Дүүрэгт Насан туршийн боловсролын төвийг байгуулахад шаардлагатай 380.9 сая төгрөгийг 2023 оны улсын төсөвт тусгуулах, хөрөнгө санхүүгийн асуудлыг шийдвэрлүүлэх тухай дэмжлэг хүссэн албан бичгийг УИХ-ын гишүүн Ц.Сандаг-Очир, Боловсролын Ерөнхий газарт тус тус хүргүүлэв. Хангай цогцолбор сургуулийг түшиглэн насан туршийн боловсролын 2 багшийг ажиллуулж байна. Багш нарын үйл ажиллагааг тогтмолжуулах, ажиллах нөхцөл боломжийг сайжруулах зорилгоор дүүргийн Дотоод аудитын албаны 1 өрөөнд ажиллуулж байна.<br>Дүйцсэн хөтөлбөрөөр 6, бичиг үсгийн сургалтад 6, хөгжлийн бэрхшээлтэй 2 хүүхэд боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна.<br>Тайлангийн хугацаанд 18 төрлийн сургалтанд 245 хүүхэд залуучуудыг хамруулав.<br>Насан туршийн боловсролын багш нарыг нийт 13 удаагийн сургалтад хамруулж, ур чадварыг дээшлүүлэв. | 90 | 90% |
| **Зорилт 2.4. Нийгмийн халамж:** Дүүргийн хүүхэд, ахмад настан, тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-т болон амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэнэ. | | | | | | | | |
| 25. | Ажил эрхэлдэггүй, нийгмийн халамжид хамрагддаггүй зорилтот бүлгийн өрх, иргэдийг нийгмийн хамгааллын суурь үйлчилгээнд хамруулан, хамт олны бүлэг бүрдүүлэн орлогын эх үүсвэртэй болгох нөхцөлийг бүрдүүлнэ. | Нийслэлийн төсөв | Орлогын эх үүсвэр нэмэгдсэн өрхийн тоо | 2021 онд 10 өрхийн 5 бүлэгт 7,5 сая төгрөгийн санхүүжилт олгосон. | Нийгмийн хамгааллын суурь үйлчилгээнд 10 өрхийг хамруулсан байна. | Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний сургалт зохион байгуулах үйлчилгээнд зорилтот бүлгийн 31 иргэн хамрагдаж 1.7 сая төгрөг, зөвлөгөө өгөх үйлчилгээнд 36 иргэн хамрагдаж 2.0 сая төгрөг зарцуулсан бол хамт олны бүлэг бүрдүүлэх орлогын эх үүсвэртэй болоход нь дэмжлэг үзүүлэх төсөл хэрэгжүүлэх үйлчилгээнд 5 бүлгийн 10 иргэнд 10.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгоод байна. | 100 | 90% |
| 26. | Дүүргийн ахмад настан, тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулж, нөлөөллийн олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ | Халамжийн сан 64,8 | Зохион байгуулсан ажлын тоо, хэмжээ Хамрагдсан хүний тоо | 2021 онд 558 ахмад настан, 84 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хөнгөлөлт тусламж олгосон байна. | Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй 600 иргэнийг нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулж | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 4 иргэн 40.0 сая төгрөг, Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 5 ахмадад 25.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгож үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж | 100 | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дэмжлэг үзүүлсэн байна. | байна.<br>ХХҮХ "Их хангайн өргөө" СӨХ-тэй гэрээ байгуулан 14 дүгээр байрны подвалийг түрээслэн 1.5 сая төгрөг зарцуулж 4 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангав.<br>Мөн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт тусламжид 472 иргэнийг хамруулж 70.8 сая төгрөг зарцуулсан байна. Монголын уламжлалт Сар шинийн баяр, Ахмадын өдрийг тохиолдуулан ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж 350 ахмадыг хамруулан Засаг даргын нөөц хөрөнгөөс 7.3 сая төгрөг зарцуулав. Ахмадуудын дунд цэнгээнт бүжгийн арга хэмжээг 7 хоног бүрийн 5 дахь өдөр зохион байгуулж хэвшээд байна. Ээжийн бүүвэй, Дуун цэнгүүн, Инээд 22, Хөгжилтэй буухиа, дөрвөн бэрх, шагай, теннис, шатар, даам, софт волейбол, хөзрийн тэмцээнийг зохион байгуулж давхардсан тоогоор 462 ахмад, 41 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамруулав. Дүүргийн ахмадын бага хурлыг 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж 60 ахмадыг хамруулан 1.4 сая төгрөг зарцуулав.<br>Ахмадын хорооны барилгыг хашаажуулах ажилд 16.1 сая төгрөг зарцууллаа. | | |
| 27. | Дүүргийн ахмадын хорооны гадна талыг хашаажуулах | Дүүргийн төсөв 16.1 | Хашаа барих ажлын явц, хувь | 2021 онд зураг төсөв нь хийгдэв. | 100 | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар Ахмадын өргөөг хашаажуулах ажлыг 16,1 сая төгрөгийн өртөгөөр "Сортшонхор" ХХК гүйцэтгэж 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр хүлээн авав. | 100 | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 28. | Хүмүүнлэгийн чиглэлээр гадаадын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, зорилтот бүлгийн өрх, иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулна. | ОУБ 16.0 | Төсөл хөтөлбөрт хамрагдсан өрх, иргэний тоо | ОУын ТББ, ААНБ-ууд, сайн дурын идэвхтнүүдээс 69.8 сая төгрөгийн хандив, тусламж олгосон. | Зорилтот бүлгийн 40 иргэнийг хамруулсан байна. | Тайваний гэр бүлийг дэмжих санд 31 өрхийн 107 хүүхэд хамрагдаж 6.4 сая, Кристина нобелийн хүүхдийг дэмжих санд 4 өрхийн 4 хүүхэд хамрагдаж 3.0 сая төгрөгийн мөнгөн тэтгэмж авсан байна.<br>Улаан загалмайн хорооноос "1000 хүүхдийн цасны баяр" арга хэмжээнд 100 хүүхэд, тусламж дэмжлэгт 20 өрх хамруулав. Мөн Кристина нобелийн хүүхдийг дэмжих санд 14 хүүхдийг хамруулахаар нөхцөл байдлын үнэлгээ хийж өрхийн мэдээллийг хүргүүлээд байна. | 100 | 90% |
| **Зорилт 2.5. Хөдөлмөр эрхлэлт:** Бүх нийтийн бүрэн, бүтээмжтэй, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. | | | | | | | | |
| 29. | Зорилтот бүлгийн иргэдийг нийтийг хамарсан үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажиллана. | Хөдөлмөр эрхлэлтийн сан 53.7 | Зохион байгуулсан ажлын тоо, хэмжээ | Нийтийг хамарсан ажилд 146 иргэнийг хамруулав. | 100-аас доошгүй иргэнийг нийтийг хамарсан ажилд хамруулсан байна. | Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг хөдөлмөрийн насны 14 иргэнийг "Борлуулалт зар сурталчилгааны ажилтан бэлтгэх мэргэжил олгох" сургалтад, 79 иргэнийг "Хөдөлмөрт бэлтгэх" сургалтад, 15-34 насны ажилгүй 3 иргэнийг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад тус тус хамруулав.<br>Уг үйлчилгээнд хамрагддаг 8 иргэнийг Төв аймгийн Жаргалант сумын ургац хураах ажилд, 7 иргэнийг мод тарих ажилд, 35 иргэнийг нийтийг хамарсан ажилд, 2 иргэнийг байнгын ажлын байраар хангав.<br>Орлого багатай иргэний өрхийн орлогыг нь нэмэгдүүлэх зорилгоор нийтийг хамарсан ажил арга хэмжээг 3 удаа зохион байгуулж, 104 иргэнийг хамруулан 45.0 сая, мод тарих арга хэмжээнд 28 иргэнийг хамруулж 8.6 сая төгрөг зарцуулав. Өрхийн үйлдвэрлэл эрхлэж буй иргэдийн бүтээлээр 2 удаагийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулж 4 бүлгийн төсөл хэрэгжүүлэгч, өрхийн үйлдвэрлэл эрхлэгч 1 иргэн оролцож 577.0 мянган төгрөгийн борлуулалт хийв. | 100 | 90% |
| 30. | Залуучуудыг бизнес эрхлэх сургалт, арга хэмжээнд хамруулан гарааны бизнес эрхлэлтийг дэмжинэ. | ЗДТГ ХХҮХ | Сургалтад хамрагдсан залуучуудын тоо | "Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж, гарааны болон | 20 залуу бизнес эрхлэлтийн сургалтад хамруулсан байна. | Залуучуудын гарааны бизнес эрхлэлтийг дэмжих "Стартап" хөтөлбөрийн хүрээнд 3 үе шаттай сургалтад 15-34 насны 32 залууг хамруулан багийн зохион байгуулалтад оруулж, дүүргээс 4 баг, нийслэлийн Стартап уралдааны сонгон шалгаруулалтад оролцов. Үүнээс 2 баг шилдэг гарааны бизнесээр шалгарч тус бүр 10.0 сая | 100 | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | санхүүгийн дэмжлэгт 3 багийн 6 залуучууд хамрагдсан. | | төгрөгийн санхүүгийн дэмжлэгт хамрагдлаа. Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар тус 2 багтай гэрээ байгуулан үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж байна.<br>ХХҮХ "ЭНДЭЭ ХӨГЖИЛ" ТББ-тай хамтран 2022 оны 10 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн загвар төвд "Биенес эрхэлж, өөрийгөө хөгжүүлэх нь" сэдвээр сургалт зохион байгуулж 19 залууг хамруулав.<br>Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх "Оролцоо" төсөлд дүүргээс 18-34 насны 4 залуу бүртгүүлснээс Олон Улсын хүүхдийн "Найрамдал" цогцолборт зохион байгуулагдсан 2-р ээлжийн 14 хоногийн вакумжуулсан сургалтад 3 залуу хамрагдав. "Оролцоо" төсөлд хамрагдсан 3 залуугаас 2 залууг ажлын байранд дадлагажуулж байнгын ажлын байртай болгоод байна. | | |
| 31. | Улс, нийслэл, орон нутгийн хөрөнгө оруулалтаар дүүрэгт хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэгч байгууллагад орон нутгийн иргэдээс тодорхой тооны иргэдийг ажлын байраар хангах асуудлыг гэрээнд тусгуулж шийдвэрлэн ажиллана. | ОНХС | Түр ажлын байраар хангагдсан иргэдийн тоо | Ажил олгогч 9 байгууллага, аж ахуйн нэгжээс давхардсан тоогоор 123 ажлын байрны захиалга авч, ажил идэвхтэй хайгч 109 иргэн ажлын байраар хангагдсан. | 5-аас доошгүй иргэнийг ажлын байраар хангасан байна. | Улс, нийслэл, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар дүүрэгт хийгдэж буй бүтээн байгуулалтын ажилд дүүргийн иргэдээс авч ажиллуулах саналыг тавьж, 2 дугаар хорооны Спорт заалны барилгын ажилд дүүргийн ажилгүй 1 иргэнийг, 1 дүгээр хорооны 1 дүгээр байрны өмнөх авто зогсоол, хороо хоорондын зам засварын ажилд 7 иргэнийг түр ажлын байраар хангав. | 100 | 90% |
| 32. | Нэг өрх, нэг ажлын байр зорилтыг хэрэгжүүлж, дүүргийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажиллана. | ЗДТГ<br>ХХҮХ | Зохион байгуулсан ажлын тоо, хэмжээ | Иргэдийг түр, байнгын ажлаар хангасан байна. | Зохион байгуулсан ажлын үр дүнгээр тооцно | ХХҮХ ажил олгогч 11 байгууллага, аж ахуйн нэгжээс давхардсан тоогоор 94 ажлын байрны захиалга авч бүртгэлтэй, ажил идэвхтэй хайгч 84 иргэн ажлын байраар хангагдсан. Үүнээс байнгын ажлын байранд 57, түр ажлын байранд-12, улирлын чанартай ажилд 15 иргэнийг зуучилсан байна.<br>Тайлангийн хугацаанд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 5 хөтөлбөрт 28 иргэн хамрагдаж 220.0 сая төгрөгийн санхүүжилт авч, хөдөлмөр эрхэлж өрхийн орлогоо нэмэгдүүлж байна.<br>Өөрөө өөртөө ажлын байр бий болгох, хувиараа хөдөлмөр эрхлэгч 12 иргэнд 95.0 сая төгрөг, | 100 | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 5 иргэнд 50.0 сая төгрөг,<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 4 иргэнд 40.0 сая төгрөг,<br>Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 5 иргэнд 25.0 сая төгрөг,<br>Малчин өрхийг малжуулах арга хэмжээний санхүүгийн дэмжлэгт 2 иргэнд 10.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож үйл ажиллагаанд нь 5 удаа хяналт тавьж ажиллав. | | |
| 33. | Хөдөлмөр эрхлэлт, боловсон хүчний судалгааг гаргаж, хөдөлмөрийн эрэлт, нийлүүлэлтийг зохицуулах мэдээллийн сан байгуулна. | - | Мэдээллийн сан бүрдүүлсэн байдал | Мэдээллийн сангийн баяжуулалтыг сайжруулсан байна. | Мэдээллийн сангийн баяжилтыг нэмэгдүүлсэн байдлаар тооцно. | ХХҮХ нь хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн сангийн баяжилтыг нэмэгдүүлж, тайлангийн хугацаанд 11 ажил олгогч байгууллага, аж ахуйн нэгжээс ирсэн 94 ажлын байрны захиалга, 22 шинэ ажлын байрны мэдээлэл болон 310 иргэний мэдээллийг санд бүртгээд байна. | 90 | 90% |
| **Зорилт 2.6. Соёл урлаг:** Хүүхэд залуучууд, иргэдийг хотын соёлд суралцуулах, мэргэжлийн байгууллагатай хамтран соёлын олон талт арга хэмжээг зохион байгуулна. | | | | | | | | |
| 34. | Дүүрэгт 500 хүний суудалтай Соёлын ордоны барилгыг барьж ашиглалтад оруулах ажлыг үргэлжлүүлж, соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулна. | Нийслэлийн төсөв 1.500.0 | Барилгын ажлын явц, хувь | Соёлын ордны барилгын шав тавигдаж, газар шорооны ажил хийгдсэн. | Батлагдсан зураг төсвийн хүрээнд барилгын ажил эхэлсэн байна. | Дүүрэгт 2021 онд нийслэлийн хөрөнгө оруулалтаар 500 хүний суудалтай Соёлын ордны барилгыг бариулахаар шийдвэрлүүлж гүйцэтгэгчээр Адамант ХХК шалгарав. Соёлын ордны барилгын нийт төсөвт өртөг 5.2 тэрбум төгрөг ба 2022 онд Нийслэлийн төсөвт 450.0 сая төгрөг тусгагдаж зоорийн давхрын арматурын ажил бүрэн дууcч, цахилгаан холболтын монтажийг хийв. 2022 оны 11 дүгээр сард 80 тн цемент, 6 машин хайрга, дайрга татан хучилт хийх үед Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газраас хүйтэрсэнтэй холбогдуулан 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрөөс ажлыг нь зогсоосон байна. Дүүргийн Засаг даргын захирамжаар барилгын ажилд хяналт тавих Ажлын хэсэг байгуулагдан 3 удаагийн хяналт тавив. | 90 | 90% |
| 35. | Мэргэжлийн урлагийн байгууллагуудтай хамтран соёл, урлагийг түгээн дэлгэрүүлэх олон талт арга хэмжээ зохион байгуулах, | Засаг даргын нөөц | Зохион байгуулагдсан соёл, урлагийн арга хэмжээний тоо | Мэргэжлийн урлагийн 14 байгууллагын тоглолтыг 840 иргэд олон | Мэргэжлийн урлагийн 3 байгууллагын тоглолтыг иргэд олон | Монгол улсын Хүүхэлдэйн театр, Консерваторийн сургууль, Үндэсний номын сантай хамтран мэргэжлийн байгууллагын тоглолт, үйлчилгээг дүүрэг орон нутагтаа зохион байгуулж иргэдийг соён гэгээрүүлж | 100 | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дугуйлан секцийг хороодод тогтмол хичээллүүлнэ. | | Хамрагдсан хүний тоо | нийтэд хүргэсэн. | нийтэд хүргэсэн байна. | 1200 гаруй иргэдийг хамруулан, 2.1 сая төгрөг зарцуулав.<br>Соёлын ордонд нийт 68 арга хэмжээ зохион байгуулагдаж, 9500 орчим иргэд, хүүхэд залуучууд хамрагдан 3.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Үүнээс: Сургалт сурталчилгааны 30 арга хэмжээ, 8 кино үзвэр, 10 тоглолт, 12 тэмцээн уралдааныг зохион байгуулсан байна. Дүүргийн Соёлын ордонд 9 төрлийн дугуйланд 92 суралцагч суралцаж байна. 2022 оны 10 дугаар сараас эхлэн морин хуурын дугуйланг хичээллүүлж эхлэв. | | |
| 36. | Соёлын биет болон биет бус өвийг хамгаалан, түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулна. | Орон нутгийн төсөв | Бүртгэлжүүлсэн хөшөө дурсгалын тоо | 2020 онд 42 хөшөө дурсгал байгааг тогтоосон. | Соёлын биет бус өвийг сурталчлан, өв тээгчдийг бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулсан байна. | Соёлын биет бус өвийг бүртгэлжүүлэх ажлын хүрээнд ich.mongoluv.mn программд 24 өв тээгчийн мэдээллийг шивж оруулав. Дүүргийн нутаг дэвсгэрт байгаа 42 хөшөө дурсгалыг тусгай маягтын дагуу бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Мөн Монгол түмний Соёлын өвийг уламжлуулах, иргэдийг үгийн бичгээ зөв хөтлөхөд дэмжлэг үзүүлэх, тэднийг сургах дадлагажуулах зорилгоор "Үгийн бичиг"-ийн танхимын сургалтыг ҮАБЗ-ийн Сургалт судалгааны хүрээлэнтэй хамтран зохион байгуулж 35 иргэнийг сургагч багшаар бэлтгэлээ.<br>"Нүүдэлчин Монгол-2022" наадамд дүүргийн соёлын биет бус өв тээгч 30 иргэнийг оролцуулан Засаг даргын нөөц хөрөнгөөс 5.9 сая төгрөг зарцуулав.<br>Мөн Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газрын даргын 2022 оны А/42 дугаар тушаалаар "Соёлын биет бус өвийн үзлэг, бүсчилсэн судалгаа"-нд дүүргийн Соёлын биет бус өв тээгч 20 иргэнийг судалгаа, асуумжид хамруулан, 2 иргэний өвийг баримтжуулан дүрсжүүлэв.<br>Эзэн богд Чингис хааны мэндэлсэн "Монгол бахархлын өдөр", "Соёлын бүтээлч сар-2022 аян"-ыг тохиолдуулан 2022.11.23-ны өдөр "Монгол өв-морин хуур" арга хэмжээг зохион байгуулж Монгол түмний үнэт соёлын өв болох уртын дуу, морин хуурыг олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, төрт ёсны морин хуур болон монгол төрийн 9 уртын | 100 | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дууг дүүргийн "Түүхийн танхим"-д залж, уран бүтээлчдийн тоглолт, морин хуурын үзэсгэлэнг зохион байгуулж 1.9 сая төгрөг зарцуулав. | | |
| 37. | Хүүхэд залуучууд, иргэдийг хотын соёлд суралцуулах, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн санал санаачлагыг дэмжиж хамтран ажиллах, Соёлын ордоны номын сангийн фондын баяжилтыг жил бүр хийж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ. | Байгууллагын төсөв 1.5 | Зохион байгуулсан ажлын тоо, хэмжээ | Соёлын ордны номын сангийн фондыг 10 хувиар нэмэгдүүлсэн байна. | Зохион байгуулсан ажлын үр дүнгээр тооцно | Дүүргийн Соёлын ордон "Хотын соёл" аяны хүрээнд 7 хоног бүр "Бүжиг" арга хэмжээг зохион байгуулж тайлангийн хугацаанд 38 байгууллага хуваарийн дагуу арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 2300 гаруй иргэд оролцсон байна. Мөн иргэдийг хүрээлэн буй орчиндоо соёлтой байх уриалга гарган 3 төрлийн видео контент бэлтгэн фэйсбүүк цахим хуудсаар иргэдэд хүргээд байна. Аяны хүрээнд 44, 207 дугаар цэцэрлэг 12 төрлийн контент бэлтгэн байгууллагын нээлттэй групп болон анги бүлгүүдийн групп дээр байршуулан эцэг эх, асран хамгаалагч, хүүхдүүдэд сурталчлан ажиллаж байна. "Хангай" цогцолбор сургууль цахим хаягаар дамжуулан нийт 156 төрлийн мэдээлэл оруулан иргэдэд түгээн ажиллалаа. 2022 оны 05 дугаар сард зохион байгуулагдсан "Номын баяр-2022" арга хэмжээнд дүүргээс оролцож иргэдэд мэдээ, мэдээллийг хүргэж ажиллав. НСУГ-аас 3.0 сая төгрөгийн өртөг бүхий 160 ш ном нийлүүлж Номын санг баяжуулав. | 90 | 90% |
| **Зорилт 2.7. Гэр бүл хүүхэд, залуучууд:** Гэр бүлийн гишүүн бүрт чиглэсэн сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажиллагаа зохион байгуулж, гэр бүлд үзүүлэх хамгааллын үйлчилгээг сайжруулна. | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 38. | Хүүхэд, залуучуудад үндэсний өв уламжлал, эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэх, хотын соёлд суралцуулах, гэр бүлийн боловсрол олгох чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөлийг сайжруулна | Байгууллагын төсөв 1.5 | Зохион байгуулсан ажлын тоо, хэмжээ | Гэр бүлийн боловсрол олгох сургалтад 800 гаруй хүүхэд, залуучууд, иргэдийг хамруулсан. | Гэр бүлийн боловсрол олгох нөлөөллийн үйл ажиллагаанд 1000 иргэнийг хамруулсан байна. | Дүүргийн ИТХ, ЗДТГ, ГБХЗХХ хамтран "Олон Улсын гэр бүлийн өдөр"-ийг тохиолдуулан 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдөр "Гэр бүлийн үнэ цэнэ" чуулга уулзалтыг зохион байгуулж, 80 гэр бүлийн 160 залуу хамрагдав. Тус чуулга уулзалтаар гэр бүл, залуучуудын чиглэлээр дүүрэгт баримталж буй бодлого үйл ажиллагаа, сэтгэл зүйч, лектор Г.Наранбаатарын "Гэр бүлийн үнэ цэнэ" лекцийг зохион байгуулж, залуучуудыг 4 салбар хуралдаанд хуваарилан хуралдуулж, 26 санал хүсэлт гаргасныг ангилан холбогдох газруудад хүргүүлээд байна. Эцэг эхийн зөвлөлүүдтэй хамтран Гэр бүлийн боловсрол олгох цахим сургалтыг 2 удаа зохион байгуулж 205 залууг хамруулав. ГБХЗХХ-ээс сар бүр гэр бүлийн өдрийг зохион байгуулах чиглэлийг ААНБ-уудад өгч 28 байгууллагын 1245 гэр бүлийг хамруулан арга хэмжээ зохион байгуулсан байна. | 100 | 90% |
| 39. | Хүүхэд, гэр бүлд үзүүлэх хамгааллын хариу үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Орон нутгийн төсөв | Зохион байгуулсан ажлын тоо, хэмжээ | Хүүхэд, гэр бүлд үзүүлэх хамгааллын үйлчилгээг зохион байгуулсан байна. | Зохион байгуулсан ажлын үр дүнгээр тооцно | "Илрүүлэлт-2022" арга хэмжээг дүүргийн Цагдаагийн хэлтэс, ГБХЗХХ хамтран 3 удаа, гэнэтийн хяналт шалгалт /илрүүлэлт/-ыг 2 удаа зохион байгуулж, уяачид, эцэг эх, асран хамгаалагчдад зөвлөгөө мэдээлэл хүргэж ажилласан байна. Хурдан морины 11 жүчээ, төмөр замын 1 өртөө, 8 зөрлөг, гар аргаар алт олборлож буй 2 цэг, үйлдвэрийн бүсд байрлах эрсдэлтэй 4 үйлдвэрээр явж зөвлөмж өгөн, уралдаанч 43, туслах уяач 6 хүүхдийг бүртгэлд авч, нийт 32 иргэн, албан тушаалтанд зөвлөгөө мэдээлэл хүргэн ажилласан байна .<br>ГБХЗХХ МӨХ-ны гишүүн, өмгөөлөгчтэй хамтран мориноос унаж нас барсан 1, бэлгийн хүчирхийллийн хохирогч 2 хүүхдийн хэргт өмгөөллийн үйлчилгээ үзүүлж байна. Уг ажилд 1.3 сая төгрөгийн гэрээ байгуулан үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.<br>Мөн хүүхдийн эрхийн зөрчлийн шинжтэй асран хамгаалагч солих хүсэлтэй-1, хүүхдээ үл хайхарсан 1, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлээгүйгээс хүүхэд бэртэж хохирсон 1, хүүхдийн бие махбодод халдсан 1 нийт 4 гомдол мэдээллийг хүлээн авч хуулийн хугацаанд зөрчил шалган шийдвэрлэх | 100 | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
